

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ НӨХЦЛИЙГ ХАНГАХ ГЭРЭЭ

Нэг. Зорилго

1.1 Энэхүү гэрээний зорилго нь нэг талаас “.....” ХХК /цаашид “Захиалагч” гэх/ болон нөгөө талаас “Ажил гүйцэтгэх гэрээ”-ний /цаашид “Үндсэн гэрээ” гэх/ дагуу өөрийн ажилтан, тоног төхөөрөмжийг захиалагчийн талбайд ажиллуулж байгаа гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч иргэн эсвэл хуулийн этгээд /цаашид “Гүйцэтгэгч” гэх/ нарын ажил гүйцэтгэх талбай дээр Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй /цаашид “ХАБЭА” гэх/-н нөхцлийг хангах талаар хүлээх эрх үүргийг тодорхойлох, мөн талууд өдөр тутмын найдвартай, хэвийн үйл ажиллагааг хангах, хүлээсэн үүрэгтээ хариуцлагатай байж аливаа үүрэг даалгаврыг чанд биелүүлж ХАБЭА-тай холбоотой аливаа асуудлыг шийдвэрлэх, осол зөрчлийг түргэн шуурхай мэдээлэх хариу арга хэмжээ авах аюулгүй ажиллагааны заавар, дүрэм журам хууль тогтоомжийг мөрдөж ажиллах, талууд хоорондын хүлээх үүрэг хариуцлага шаардлагуудыг тодорхойлоход оршино.

1.2 ХАБЭА-н нөхцлийг гүйцэтгэгч нь бүрэн хэрэгжүүлж хариуцах бөгөөд энэхүү гэрээний үйл ажиллагааны хэрэгжилтэнд захиалагч хяналт тавьж ажилна.

Хоёр. Хэрэглэх хүрээ, хэрэгжих хугацаа

2.1 Энэхүү гэрээг захиалагч байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж Гүйцэтгэгч, түүний хариуцан, хамтран ажиллаж байгаа бүх ажилтнууд үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.

2.2 ХАБЭА-ны гэрээ нь Үндсэн гэрээний хугацаа дуусах хүртэл хугацаанд үргэлжлэх бөгөөд Үндсэн гэрээний ажил дуусаж гэрээг дүгнэх хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

Гурав. Гүйцэтгэгчийн эдлэх эрх, хүлээх үүрэг

3.1 Гүйцэтгэгч нь захиалагчийн гаргасан ХАБЭА-н талаарх менежементийн төлөвлөгөөтэй /ХАБЭА-ны дүрэм, журам, зааварчилгаа гэх мэт/ танилцаж ажлын туршид түүнтэй холбоотой бүх дүрэм журмуудыг дагаж мөрдөнө.

3.2 Гүйцэтгэгч нь ХАБЭА-н зааварчилгааны стандартын дагуу өдөр бүр ажилчиддаа аюулгүй ажиллагааны зааварчилгааг тухайн ажлын онцлогт тохируулан өгч гарын үсэг зуруулсан байна. Хэрэв Гүйцэтгэгч нь тухайн төлсийн ажлын талбайд ажиллах ажилчинд зааварчилгаа өгөөгүй, ХАБЭА-н зааварчилгааны дэвтэрт гарын үсэг зуруулаагүйгээс үүдэн гарах асуудлыг гүйцэтгэгч бүрэн хариуцах үүргийг хүлээнэ.

3.3 Эрүүл аюулгүй ажлын орчинд ажиллах нөхцлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн бүх арга хэмжээг авч ажиллах бөгөөд гүйцэтгэгч нь энэ үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай дэмжлэг туслалцаа авах, түр ажил болон ажилд зохих өөрчлөлт оруулах талаар захиалагч байгууллагад тухай бүр санал хүсэлтээ тавьж шийдвэрлүүлэх эрхтэй

.... Үргэлжлэл бий ...4х